



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, сэргээн засварлах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2013 оны 02/07-891978 дугаар актаар тогтоогдсон, нийт 61,124,616.00 (жаран нэгэн сая нэг зуун хорин дөрвөн мянга зургаан зуун арван зургаан) төгрөгийн балансын үнэ, 2,444,985.00 (хоёр сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга есөн зуун наян таван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ж.Солонгод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг байгууллагын мэдэлд хэвээр үлдээж албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4. Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
394 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ**

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Автогражийн барилга	1976.01.01 2018.12.31 (дахин үнэлгээ)	61,124,616.00	61,124,616.00	2,444,985.00	58,679,631.00
	Нийт дүн			(жаран нэгэн сая нэг зуун хорин дөрвөн мянга зургаан зуун арван зургаа)	(хоёр сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга есөн зуун наян тав)	(тавин найман сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун гучин нэг)